



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/520

Улаанбаатар хот

**Чингэлтэй дүүргийн 37 дугаар цэцэрлэгийн
балансаас хөрөнгө шилжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 6,270,000 /зургаан сая хоёр зуун далан мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг Чингэлтэй дүүргийн 275 дугаар цэцэрлэгийн балансад шилжүүлж, данс бүртгэлээсээ хасахыг Чингэлтэй дүүргийн 37 дугаар цэцэрлэг /С.Сэлэнгэ/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжин ирсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан бүртгэж авахыг Чингэлтэй дүүргийн 275 дугаар цэцэрлэг /Б.Алтантуяа/-т даалгасугай.

3. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Чингэлтэй дүүргийн 37 дугаар цэцэрлэг /С.Сэлэнгэ/-т, Чингэлтэй дүүргийн 275 дугаар цэцэрлэг /Б.Алтантуяа/-т тус тус үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

115060001323

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 10 дугаар сарын 23 өдрийн
A/520 дугаар тушаалын хавсралт



Балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Чингэлтэй дүүргийн 37 дугаар цэцэрлэг

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар	Ашиглалтанд авсан он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Шилжүүлэн авах байгууллага
Тавилга эд хогшил										
1	Чингэлэг	40тн	2019	ш	1	6,270,000	6,270,000	1,254,000	5,016,000	Чингэлтэй дүүргийн 275 дугаар цэцэрэг
Тавилга эд хогшлын дүн							6,270,000	1,254,000	5,016,000	